

БАТЛАВ  
 ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
 ЯАМ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
 ДАРГА *Б.Батцэцэг* Б.БАТЦЭЦЭГ  
 2024 оны ... дугаар сарын ...

**НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД ХЭРЭГЛЭГДЭХ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЗАГВАР  
 НЭВТРҮҮЛЭХ, ХӨГЖҮҮЛЭХ**

Д.д	Нэр төрөл	Тайлбар
1	Зорилго	<p>Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 7.3 дахь зорилтын 7.3.17 дахь заалтад “Инновацад суурилсан техник, технологийн шинэчлэлийг сайжруулж, кибер гэмт хэргээс хамааралтай цахим нотлох баримтыг бэхжүүлэх, үнэлэх, хиймэл оюун ухааныг ашиглах чадамжийг хөгжүүлж, энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.”, Монгол хэлний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дахь заалтад “Цахим орчинд монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх.” гэж тус тус заасныг үндэслэн нээлттэй мэдээллийн системд хэрэглэгдэх хиймэл оюун ухааны загвар нэвтрүүлэх, хөгжүүлэх.</p>
2	Захиалагч байгууллага	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
3	Гүйцэтгэх ажил	<p>Нээлттэй мэдээллийн системд хэрэглэгдэх хиймэл оюун ухааны загварыг нэмэлт өгөгдлөөр сургаж нэвтрүүлэх, хөгжүүлэх.</p> <p>Зорилго:</p> <ol style="list-style-type: none"> <li>Хиймэл оюун ухааны загварыг shilen.gov.mn-д байршсан өгөгдлөөр сургаж хөгжүүлэх;</li> <li>Загварын нарийвчлал, хэрэглэгчийн асуулт, даалгаварт үзүүлэх хариу үйлдэл чадварыг сайжруулах.</li> </ol> <p>Үйл ажиллагаа:</p> <ol style="list-style-type: none"> <li>Хиймэл оюун ухааны загварыг нэмэлт өгөгдлөөр сургах;</li> <li>Цуглуванс өгөгдлийг загварын шаардлагад нийцүүлэн цэвэрлэх, тайлбар хийх, форматын өөрчлөлт хийх;</li> <li>Одоогийн хиймэл оюун ухааны загварыг бэлтгэсэн өгөгдлөөр сургах, загварын гүйцэтгэлийн сайжруулалтыг үнэлэх зорилгоор нарийвчлалын шалгалт хийх;</li> <li>Шинэчлэгдсэн загварыг нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn) дээр нэвтрүүлэх;</li> <li>Гэрээ байгуулснаас хойш 3 жилийн хугацаанд нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д орсон өгөгдлийг хиймэл оюунаар сургаж чатбotoор харилцах чадварыг сайжруулна.</li> </ol>

4	Ажил гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэгч нь захиалагчтай гэрээ байгуулснаас хойш 3 сарын дотор ажлыг бүрэн хийж гүйцэтгэнэ.
5	Хяналт, шалгалт	Захиалагч нь шаардлагатай бол гүйцэтгэлийн шатанд хяналт шалгалт хийнэ.
6	Хүлээлгэн өгөх материал	<ul style="list-style-type: none"> <li>- Ажил гүйцэтгэлийн тайлан;</li> <li>- Цуглуулсан өгөгдлийн тайлан;</li> <li>- Загварын сургалт, туршилтын үе шатын тайлан;</li> <li>- Ашигласан технологи, арга зүй;</li> <li>- Шинэчлэгдсэн хиймэл оюун ухааны загварыг нээлттэй мэдээллийн системд байршуулсан байна;</li> </ul>